



БУЛГАН АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 8/01

Булган сум

Байгууллагын төрийн албан хаагчдын  
цалин шинэчлэн тогтоох ажлын хэсгийн  
бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, “Төрийн албаны тухай” хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2, 57.2.4, 57.17, 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалтууд, аймгийн Засаг даргын 2021 оны А/439 дүгээр захирамж, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт төрийн албан хаагчдын 2023 оны цалин шинэчлэн тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Шинээр батлагдан гарсан Засгийн газрын тогтоолууд болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг баримтлан төрийн албан хаагчдын 2023 оны цалинг шинэчлэн тогтоож, нийт төрийн албан хаагчдыг эргэн мэдээллээр ханган ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (П.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.


3. Төрийн албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан, төрийн албан хаагчийн хувийн хэрэгт нэмэлт баяжилт хийж, санхүүгийн ил тод байдлын зарчмыг баримтлан ажиллахыг Салбарын эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (П.Мягмарсүрэн), Байгууллагын хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Б.Батцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАРАНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
01 дүгээр сарын 10 -ны өдрийн  
А/01 дугаар тушаалын хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

П.Мягмарсүрэн-Салбарын эдийн засаг, төсвийн төлөвлөлт  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Д.Нарантуяа-Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга  
Б.Урангаваа-Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн  
дарга  
Б.Гантулга – Хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл, эмнэлгийн  
мэргэжилтний ёс зүй хариуцсан мэргэжилтэн  
Б.Батцэцэг- Байгууллагын хүний нөөц, дотоод ажил хариуцсан  
мэргэжилтэн